



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/39

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд отроор явж буй малчин өрхүүдэд буцалтгүй тусламж олгох зардалд 2,368,800 (хоёр сая гурван зуун жаран найм мянга найман зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 2,368,800 (хоёр сая гурван зуун жаран найм мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН